



# Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Дорноговь аймгийн 13 сумын эвдэрсэн газрын тооллого бүртгэл



Айраг сум




Алтан ширээ сум




Даланжаргалан сум




Дэлгэрэх сум




Их хэт сум



Мандах сум



Өргөн сум



Сайншанд сум



Сайхандулаан сум



Хатанбулаг сум



Хөвсгөл сум



Улаанбадрах сум



Эрдэнэ сум



*Дорноговь аймгийн хэмжээнд ашигт малтмал  
олборлогч иргэд, аж ахуйн нэгжийн үйл  
ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын  
тооллого, нөхөн сэргээлтийн зардлын тооцоо*

Дорноговь аймгийн хэмжээнд ашигт малтмал олборлогч иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын тооллого, нөхөн сэргээлтийн зардлын тооцоо



**ЗАХИАЛАГЧ**

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА

Д.СҮРЭН



**ГҮЙЦЭТГЭГЧ**

“ЖЭМР” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БУЛГАНБАЯР

## **Талархал**

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (БОАЖГ)-аас захиалан 13 сумын нутагт ашигт малтмал олборлогч иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг тоолж бүртгэн, хэмжилт, судалгаа хийх, нөхөн сэргээлтэд шаардагдах зардлыг тооцох, эзэн хариуцагчийг тогтоох, авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулах мэргэжлийн зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэхүүлэхээр ЖЭМР ХХК-ийг сонгон шалгаруулж улмаар тооллогын ажилд өндөр ач холбогдол өгч, аймаг, сумдын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж газарчлуулан, нэмэлт унаа гарган тусалж, тухайн газар нутгийн онцлог, анхаарах зүйлийн талаар үнэтэй санал зөвлөмж өгч дэмжин ажилласан Аймгийн БОАЖГ-ын дарга Д.Сүрэн, Уул уурхай, үнэлгээний мэргэжилтэн Д.Болормаа, Сайншанд сумын БОУБ Т.Ганмөнх, Зүүнбаян тосгоны зам тээвэр, харилцаа холбоо, байгаль орчин, хот тохижилт хариуцсан мэргэжилтэн Ж.Майра, Иххэт сумын БОУБ М.Ганбат, Айраг сумын БОУБ Б.Сайнзаяа, ХАА тасгийн бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Т.Бямбацогт, Даланжаргалан сумын БОУБ Э.Энхсугар, Дэлгэрэх сумын Засаг дарга Г.Банзрагч, БОУБ М.Баттулга, Алтанширээ сумын БОУБ Э.Ундармаа, Сайхандулаан сумын БОУБ Э.Гомбосүрэн, Улаанбадрах сумын ЗДТГ-ын дарга М.Хишигбаяр, БОУБ н.Энхжаргал, Хатанбулаг сумын Засаг даргын орлогч Г.Ганмөнх, БОУБ Э.Баттүвшин, Хөвсгөл сумын БОУБ Б.Мөнхцэцэг, Элст багийн дарга С.Оюунбат, Эрдэнэ сумын БОУБ Ж.Энхцэцэг, Өргөн сумын Засаг дарга Ц.Мөнхдаваа, Засаг даргын орлогч М.Түмэнбаяр, БОУБ Г.Нямцэцэг, Мандах сумын БОУБ Б.Дүүриймаа нарт гүн талархал илэрхийлж байна.

Энэ ажлыг ЖЭМР ХХК байгаль орчин, газар зохион байгуулалт, зурагзүй, мэдээллийн технологийн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдийн оролцоо, дэмжлэг тусламжтайгаар гүйцэтгэж, үүнд өндөр нарийвчлал бүхий нисгэгчгүй төхөөрөмж, газрын зураг ба мэдээлэл боловсруулалтын хөгжингүй арга технологи ашигласан зэрэг нь цаашид ийм төрлийн ажлыг гүйцэтгэх хөтөлбөр, аргачлал боловсруулахад чиглэл, санаа өгөх ач холбогдолтой боллоо.

Доктор Р.Оюун,  
ЖЭМР ХХК-ний Ерөнхий захирал

## Гарчиг

<b>1. ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>5</b>
1.1. Ажлын зорилго.....	5
1.2. Захиалагчийн өгсөн Ажлын даалгаварын биелэлт.....	5
1.3. Зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн явц.....	6
1.3.1. Бэлтгэл ажил.....	6
1.3.2. Эвдэрсэн газрын тооллого.....	7
1.3.3. Хэмжилт, судалгааны боловсруулалт, тооцоолол.....	8
1.3.4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ, зардлын тооцоо.....	12
1.3.5. Тооллого, үнэлгээ, тооцооны үр дүн.....	12
1.3.6. Эвдэрсэн газрын мэдээллийн сан.....	13
1.3.7. Үр дүнгийн тайлан, баталгаажуулалт.....	13
1.4. Ажил гүйцэтгэсэн хугацаа.....	13
1.5. Зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэсэн баг.....	13
<b>2. ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТООЛЛОГЫН ДҮН.....</b>	<b>15</b>
2.1. Нэгтгэсэн үр дүн.....	15
2.1.1. Эвдэрсэн газрын талбай, овоолго, ухшийн эзлэхүүн.....	17
2.1.2. Нөхөн сэргээлтийн тооцоо.....	17
2.2. 13 сумын эвдэрсэн газар.....	18
2.2.1. Айраг.....	18
2.2.2. Алтанширээ.....	20
2.2.3. Даланжаргалан.....	21
2.2.4. Дэлгэрэх.....	24
2.2.5. Иххэт.....	24
2.2.6. Мандах.....	26
2.2.7. Өргөн.....	27
2.2.8. Сайншанд.....	28
2.2.9. Сайхандулаан.....	29
2.2.10. Хатанбулаг.....	31
2.2.11. Хөвсгөл.....	31
2.2.12. Улаанбадрах.....	32
2.2.13. Эрдэнэ.....	32
2.3. Эвдэрсэн газрын дэлгэрэнгүй бүртгэл.....	34
<b>3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДЛЫН ТООЦОО.....</b>	<b>76</b>

<b>4. ЭВДЭРСЭН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН САН .....</b>	<b>81</b>
<b>5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....</b>	<b>82</b>
5.1. Дүгнэлт.....	82
<b>6. ХАВСРАЛТ .....</b>	<b>85</b>
6.1. Улаанбадрах сумын Засаг даргаас ирүүлсэн албан тоот.....	85
6.2. Дорноговь аймгийн ургамалжилтын индекс (2014-2018, 2020 оны 6-8 дугаар сарын дундаж) үр дүн .....	86
6.3. Эвдэрсэн газрын тооллого бүртгэл.....	99
6.4. Нөхөн сэргээлтэнд ашиглах техник, тоног төхөөрөмжийн үзүүлэлт.....	105
6.5. Хөвсгөл сумын Засаг даргаас хэмжилт хийсэн тухай албан тоот.....	108

## Зургийн жагсаалт

Зураг 1. Хээрийн хэмжилт хийж буй байдал .....	7
Зураг 2. Дроны зураг ашиглан эвдрэлд орсон газрын талбайн хэмжээг тооцсон жишээ (Алтанширээ сум, Жоншт толгой).....	11
Зураг 3. Эвдэрсэн газрын талбайд сум бүрийн эзлэх хувь.....	15
Зураг 4. Эвдэрсэн газрын сумын нутагт эзлэх хувь .....	16
Зураг 5. Эвдэрсэн талбайн хэмжээ, га.....	16
Зураг 6. Эвдэрсэн газрын төрөл, талбайн хэмжээ га.....	16
Зураг 7. Айраг сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ.....	19
Зураг 8. Алтанширээ сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ.....	21
Зураг 9. Даланжаргалан сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ.....	22
Зураг 10. Дэлгэрэх сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	24
Зураг 11. Иххэт сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	25
Зураг 12. Мандах сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ.....	27
Зураг 13. Өргөн сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ.....	28
Зураг 14. Сайншанд сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	29
Зураг 15. Сайхандулаан сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	30
Зураг 16. Хатанбулаг сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	31
Зураг 17. Хөвсгөл сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	32
Зураг 18. Улаанбадрах сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	33
Зураг 19. Эрдэнэ сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ .....	33

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Захиалагчийн ажлын даалгаварыг биелүүлсэн байдал.....	5
Хүснэгт 2. Сентинел-2 дагуулын мэдээгээр хөрс, ургамалжилт, усны индекс тооцоолсон томъёо .....	10
Хүснэгт 3. Хиймэл дагуулын мэдээ татаж авах, боловсруулах, үр дүн гаргах үе шат, товч агуулга .....	10
Хүснэгт 4. Судалгааны багийн гишүүдийн үүрэг .....	13
Хүснэгт 5. Эвдэрсэн газрын тооллого хийхэд оролцсон аймаг, сумын мэргэжилтнүүд.....	14
Хүснэгт 6. Эвдэрсэн газрын талбай, овоолго, ухшийн эзлэхүүн.....	17
Хүснэгт 7. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн зардлын дүн (сумаар).....	17
Хүснэгт 8. Эвдэрсэн газрын тодорхойлолт (талбай тус бүрээр).....	35
Хүснэгт 9. Техникийн нөхөн сэргээлт хийх ажлын 1 га талбайн үнэлгээ .....	76
Хүснэгт 10. Биологийн нөхөн сэргээлт хийх ажлын 1 га талбайн үнэлгээ .....	77
Хүснэгт 11. Эвдэрсэн газар тус бүрийн нөхөн сэргээлтийн зардлын тооцооны дүн.....	78

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Ажлын зорилго

Энэхүү зөвлөх үйлчилгээний энэ ажил нь Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (БОАЖГ)-ын 2021 оны 09-р сарын 28-ны өдрийн 341 дугаар албан бичгийн хавсралтад заасан “Ажлын даалгавар”-ын дагуу Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт, Өргөн, Мандах, Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумдын нутагт ашигт малтмал олборлогч иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг тоолж бүртгэн, хэмжилт, судалгаа хийж, нөхөн сэргээлтэнд шаардагдах зардлыг тооцох үндсэн зорилготой юм.

БОАЖГ-аас 2021 оны 09-р сард нээлттэй зарласан сонгон шалгаруулалтад “ЖЭМР” ХХК шалгарч 2021 оны 10-р сарын 29-ний өдөр №2021/17 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, 2021 оны 11-12 сард хэмжилт судалгаа, тооцоолол, боловсруулалтыг ажлыг хийж гүйцэтгэлээ.

### 1.2. Захиалагчийн өгсөн Ажлын даалгаварын биелэлт

Захиалагчийн тавьсан зорилго, өгсөн даалгаврыг “ЖЭМР” ХХК бүрэн биелүүлэв. Биелэлтийн байдлыг даалгавар тус бүрээр дараах хүснэгтэд нэгтгэн тайлбарлав.

#### Хүснэгт 1. Захиалагчийн ажлын даалгаварыг биелүүлсэн байдал

	Ажлын даалгавар	Биелэлт
1	Тооллогын ажилд аймаг, орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль орчны мэргэжилтнүүдийг оролцуулж мэдээлэл авч хамтран ажиллах, тухайн газарт олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хууль бус олборлогчид, эзэн хариуцагчийг сумдын БОХУ-ын байцаагч нартай хамтран тогтоох	<ul style="list-style-type: none"> <li>Тооллого хийх сумдын байгаль орчны улсын байцаагч нартай танилцаж, хэрийн хэмжилтийн маршрут, цагийн хуваарийг хамтран гаргаж төлөвлөгөөний дагуу ажилласан.</li> <li>Тооллого, хэмжилтийн ажилд 13 сумын БОУБ болон зарим сумдын баг, сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, ХАА бэлчээрийн мэргэжилтэн нар оролцсон.</li> <li>Эвдэрсэн газрын эзэн, хариуцагчтай холбоотой мэдээллийг аймаг, сумын мэргэжилтнүүдээс авсан.</li> <li>13 суманд 144 эвдэрсэн, 4 нөхөн сэргээлт хийсэн газар, нийт 148 газар бүртгэгдсэн.</li> </ul>
2	Сүүлийн үеийн багаж тоног төхөөрөмж ашиглан хэмжилт хийж сансрын зураг ашиглах замаар эвдрэлд орсон газрын тоо, талбайн хэмжээг нарийвчлан тогтоож солбицлуудыг тэмдэглэн, фото зургаар баримтжуулах	<ul style="list-style-type: none"> <li>Эвдрэлд орсон газрын тооллого нь 2021.11.02-19-ний өдрүүдэд нийт 18 хоног үргэлжилсэн бөгөөд MAVIC 2 pro дроноор зураг авах, Garmin GPS-ээр байршлыг тогтоох, Canon фото зургаар баримтжуулах ажил хийгдсэн.</li> <li>Хэмжилтийн дүнгээр эвдэрсэн газрын байршил, хил, уурхайн олборлосон газрын овоолго, ухашийн эзлэхүүнийг гаргаж, зурагласан.</li> <li>Өндөр нарийвчлал бүхий Сентинел, Модис хиймэл дагуулын мэдээллийг ашиглан ургамалжилтын индекс, эвдэрсэн газрын ухашийн эзлэхүүн, ус, хөрс, ургамлын индексийг тооцсон.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Ажлыг төлөвлөхүд нийт хэдэн талбайд тооллого, хэмжилт хийх нь тодорхойгүй байсан ба хээрийн хэмжилтийн хугацаа төлөвлөснөөс 4 хоногоор хойшилсон. Мөн гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхийн тулд газар дээрх хэмжилтийн мэдээ, дроны зургийн боловсруулалтыг хийж эвдрэлд орсон талбайн хэмжээг гаргасан.</li> <li>Сум тус бүрээр мэдээллийн сан үүсгэсэн ба үүнд фото зураг, дроны зураг, эвдрэлд орсон талбайн хэмжээ /shp/, хүснэгтэн мэдээлэл багтана.</li> </ul>
3	Эвдрэлд орсон газруудын нэгдсэн зураглалыг ArcGIS программ ашиглан хийх /shp файлаар мэдээллийн сан үүсгэх/	<ul style="list-style-type: none"> <li>Газрын зураглалын ArcGIS, дроны зураглал боловсруулалтын AGISOFT болон Sentinel 1, 2 хиймэл дагуулын мэдээлэл боловсруулалтын ENVI, эвдэрсэн газрын 3D зургийг ARCSCEEN программ хангамж ашиглан тус тус боловсруулсан.</li> <li>Эвдэрсэн газрын хилийг shp файлаар, өндрийн тоон загвар, дрон болон хиймэл дагуулын мэдээллийг img, geotiff форматаар бэлтгэж Захиалагчид хүлээлгэн өгсөн.</li> </ul>
4	Тооллогын үр дүнг эцэслэн гаргаж харьцуулсан дүн шинжилгээ хийж, цаашид тухайн газар тус бүрт авах арга хэмжээний санал боловсруулах	Хэрэгжих боломжтой, бодитой үр дүн өгөх арга хэмжээний санал боловсруулж Захиалагчид хүлээлгэн өгсөн.
5	Эвдрэлд орсон газар тус бүрт тухайн газрыг нөхөн сэргээх зардлыг тооцох	Ашигт малтмал олборлох үйл ажиллагааны явцад үүссэн эвдрэлийг нөхөн сэргээх ажлын үе шат, Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг “Нөхөн сэргээх ажлын зардал тооцох аргачлал”-ын дагуу 1 га талбайн нэгж зардлыг тооцож гаргасан ба талбай тус бүрт тохирох нөхөн сэргээлтэнд ашиглан тооцооллыг хийв.
6	Эвдэрсэн газрын бүртгэлийг ажлын даалгаварт заасан байдлаар ангилсан байх	Эвдэрсэн газрыг бүртгэлийг ажлын даалгаварт заасны дагуу ангилж хүснэгтэн мэдээллийг сум тус бүрээр бэлтгэсэн. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 1.3.5 болон Бүлэг 2-т дэлгэрэнгүй үзүүлэв.

### 1.3. Зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн явц

Захиалагчийн ажлын даалгаварт заасан ажлыг ЖЭМР ХХК дараах 7 үе шаттай хийж гүйцэтгэсэн:

1. Бэлтгэл ажил
2. Эвдэрсэн газрын тооллого хийх (Хээрийн хэмжилт, судалгаа)
3. Хэмжилт, судалгааны боловсруулалт, тооцоолол
4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ, зардлын тооцоо хийх
5. Тооллого, үнэлгээ, тооцооны үр дүнг нэгтгэн тайлан бичих
6. Мэдээллийн сан үүсгэх
7. Үр дүнг танилцуулах, баталгаажуулах, хүлээлгэн өгөх

#### 1.3.1. Бэлтгэл ажил

Энэ үе шатанд М1:100 000 масштабтай зураг болон Google earth хиймэл дагуулын мэдээллээс судалгаанд хамрагдах сумдын зургийг тасалж хэвлэн ажлын зураг бэлтгэсэн. Мөн сум бүрийн нутгаар Сентинител хиймэл дагуулын мэдээлэл бэлтгэн, тайлал хийж үйл ажиллагаа явуулж байгаа томоохон хэмжээний эвдэрсэн газрын



байршлыг тодорхойлсон. Аймгийн БОАЖГ-тай холбогдон сумдын байцаагч нартай уулзах, мэдээлэл өгөх, хээрийн судалгааны өдрийг товлох, хэмжилт, судалгааны мэдээлэл бүртгэх маягт, хэмжилтийн багаж хэрэгсэл, унаа машин бэлтгэх, судалгааны багийн гишүүдийн хувийн бэлтгэлийг хангуулах зэрэг ажлыг хийсэн.

### 1.3.2. ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТООЛЛОГО

Эвдэрсэн газрын тооллогыг Сайхандулаан сумаас эхэлсэн бөгөөд үүнд аймгийн БОАЖГ-ын дарга, мэргэжилтэн, сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, байгаль орчны улсын байцаагч, ХАА бэлчээрийн мэргэжилтэн, ЖЭМР ХХК-ний гүйцэтгэх захирал, байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн, газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн, газар зохион байгуулагч, жолооч нийт 26 хүн оролцсон.

Судалгааны багийнхан сумдын БО-ны байцаагч нарын газарчилсан эвдэрсэн газруудад очиж MAVIC 2 Pro нисгэгчгүй төхөөрөмж (дрон)-өөр зураглах, GPS-ээр байршлыг тогтоох, фото зургаар баримтжуулах ажил хийгдсэн. Эвдэрсэн газрын хариуцагчийн талаарх мэдээллийг сумдын БОУБ, газрын даамал нараас авсан. Нөхөн сэргээлтэд ашиглах техникийн талаарх мэдээлэл дутмаг байсан. Сайхандулаан, Мандах, Даланжаргалан сумдад эвдэрсэн газрын ихэнхийг гар аргаар ашигт малтмал олборлогчид ухсан тул нөхөн сэргээлтийг хариуцах эзэнгүй болсон байна. Бусад сумдын хувьд гар аргаар ашигт малтмал олборлогчид нилээдгүй талбайг эвдрэлд оруулсан хэдий ч дийлэнх талбай нь хариуцах эзэн холбогдогчтой байна. Даланжаргалан, Мандах сумын нутагт нөхөн сэргээсэн талбай тус бүр 1, мөн Даланжаргалан сумын Дунд ханан гэх газарт нөхөн сэргээлт хийгдэж байсан. Судалгаанд хамрагдсан газар нутаг том, эвдэрсэн газар олон, гэрээнд заасан хугацаа богино байсан хэдий ч аймгийн БОАЖГ, сум, багийн Засаг дарга, БОУБ, нарын дэмжлэг, туслалцааны дүнд тооллого судалгаа төлөвлөсөн хэмжээнд бүрэн хийгдсэн. Улаанбадрах суманд бүртгэл тооллого хийх гэж очсон боловч сумын нутаг дэвсгэрт эвдрэлд орсон газар байхгүй тиймээс тооллого хийлгэхгүй тухай Засаг даргаас албан тоот ирүүлсэн тул үйл ажиллагаа явуулж буй “Бадрах Энержи” ХХК-ний уурхайн газар дээр очиж фото зураг авч баримтжуулаагүй болно. Албан тоотыг Хавсралт 6.1-с үзнэ үү. Хээрийн судалгаа хийгдэж буй байдлын талаарх жишээ зургийг Зураг 1-с, сум тус бүрийн фото зураг, дроны зургийг файлаар нь хүргүүлсэн болно.

Зураг 1. Хээрийн хэмжилт хийж буй байдал





Сайхандулаан сум, Баянхошууны сайр



Алтанширээ сум, Жоншт толгой



Мандах сум, Үхэр чулуут



Хатанбулаг сум, Цагаан хад



Даланжаргалан сум, Майхан дэл



Даланжаргалан сум, Холбоо цагаан

### 1.3.3. ХЭМЖИЛТ, СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ, ТООЦООЛОЛ

#### Хиймэл дагуулын мэдээллийн боловсруулалт

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны аргачилсан зааварт газрын гадаргын механик өөрчлөлт, хөрс-ургамалан нөмрөгийн төлөв байдлыг тодруулах, хатуу хучилттай зам, талбай, авто зам, гуу жалга, элсний нүүлт, эвдэрч, талхлагдаж ургамалгүй халцгай болсон газар зэргийг тодорхойлоход агаар, сансрын зураг ашиглах тухай заалт бий. Хиймэл дагуулын мэдээлэл ашиглаж газар ашиглалт, өөрчлөлт, эвдрэл, элэгдэл, доройтол, цөлжилтийн байдлыг тодорхойлсон, үнэлсэн талаар гадаад

орнуудад хийгдсэн судалгааны олон материал бий. Манай орны хувьд 1980-аад оны дунд үеэс хиймэл дагуулын тоон мэдээлэл ашиглаж эхэлсэн бөгөөд ус, цаг уур, ургамал, цасан бүрхүүл, газар ашиглалт, газрын бүрхэвч, ус, хөрсний чийгшил, ууршилт, ган зуд, ой, хээрийн түймэр, агаар мандлын аэрозол, тунгалагшил, бохирдол, мөнх цас мөс зэрэг байгаль орчны олон үзүүлэлтүүдийг тодорхойлох, үнэлэх, мониторинг хийх талаар олон тооны судалгааны ажил хийгдэж ирсэн.

Монгол орны нийт нутгаар газар ашиглалт, газрын бүрхэвч, газрын доройтол, цөлжилтийн зургийг 2005, 2010, 2015 онуудад хийсэн байдаг. Албан ёсны мэдээгээр Монгол орны нийт нутгийн 76 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн гэж үздэг. Түүний 56% нь байгалийн үзэгдэлтэй, 44% нь хүний үйл ажиллагаатай холбоотой гэсэн судалгааны дүгнэлт бий. Ийм судалгааг аймаг, сум, багийн нутаг, гол усны ай сав, дэд сав, уул, голын хөндийгөөр нарийвчлан хийж байгал цаг уур, хүний үйл ажиллагааны нөлөөлөл, эрсдэлийг үнэлж газар, бэлчээрийн эвдрэл, элэгдэл, талхагдал, доройтлыг багасгах, нөхөн сэргээх, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг байршлыг нь зааж тодорхой төлөвлөдөг, хэрэгжүүлдэг болох зайлшгүй шаардлагатай.

Дорноговь аймгийн хэмжээнд уул уурхайд өртсөн газрын тооллого бүртгэл, хохирол, нөхөн сэргээлтийн судалгаа, тооцоолол, үнэлгээ хийлгэж байгаа нь байгаль орчныг хамгаалах, тогтвортой, ногоон хөгжлийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд бусад аймгуудад үлгэр дууриал болох сайн жишээ мөн.

**Ашигласан мэдээлэл:** Дорноговь аймгийн эвдэрсэн газрын судалгаа, үнэлгээнд Aqua, Terra, Sentinel 1, Sentinel 2 хиймэл дагуулын мэдээлэл ашиглав. Мэдээний ялгах чадвар, давтамжаас хамааран дараах зорилгоор ашигласан:

1. **Aqua, Terra хиймэл дагуулын МОДИС мэдээ** (нарийвчлал 250м x 250м): Ургамал бүрхэвчийн орон зайн ялгаатай байдал, өөрчлөлтийн ерөнхий зургийг гаргах;
2. **Sentinel – 1 дагуулын мэдээ** (10м x 10 м): Газрын гадаргуугийн өндрийн тоон мэдээ ашиглан хонхор газрыг тодорхойлох;
3. **Sentinel – 2 дагуулын мэдээ:** Ус, хөрс, ургамлын индексийн мэдээгээр эвдэрсэн, доройтсон газрыг тодорхойлох.

Дорноговь аймаг болон сумдын ургамалын төлөв байдал, өөрчлөлтийг жил тус бүрээр тодорхойлоход цаг хугацааны давтамж өндөртэй, 250 метрийн ялгах чадвартай МОДИС мэдээг ашигласан. Үүнд 2014-2018, 2020 оны 6-8 дугаар сарын дундаж ургамалжилтын индекс NDVI-ээр ургамал бүрхэвчийн зураг хийсэн (2019 оны мэдээ алдаатай байсан учир оруулаагүй). МОДИС NDVI мэдээг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Зайнаас тандан судлах төвөөс авсан.

Sentinel (цаашид Сентинел гэх) хиймэл дагуулын мэдээ нь МОДИС мэдээтэй харьцуулахад 25 дахин сайн ялгах чадвартай (10 метр) тул газрын бүрхэвч, ус, хөрс, ургамалын орон зайн тархалт, ялгаатай байдал, эвдэрсэн, талхлагдсан газрыг тогтоох, спектрийн болон статистик үзүүлэлтүүдийг тодорхойлоход ашигласан. Үүнд Сентинел-1 дагуулын 2021 оны 11-р сарын 10-22-ны өдрийн өндрийн мэдээ, Сентинел -2 дагуулын мэдээ 2021 оны 7 дугаар сарын оптик мэдээг Интернэтээс татаж авч ашигласан.

**Аргачлал:** МОДИС NDVI мэдээг боловсруулахад ENVI, зураглахад ArcGIS программ ашигласан. Сентинел-2 дагуулын мэдээгээр хөрс, ургамалжилт, усны индекс бодоход SNAP, олон сувгийн мэдээлэл нэгтгэж боловсруулах, дүрс, тоон үзүүлэлт шинжих, ялгах,

ангилал хийх, статистик үзүүлэлт тооцоолоход ENVI, зураглал хийхэд ArcGIS программ ашигласан.

Эвдэрсэн газрыг тодорхойлохын тулд Сентинел-2 дагуулын оптик хэмжилтийн мэдээгээр индекс бодох (индексүүдийг гаргах томъёог Хүснэгт 2-д үзүүлэв), орон зайн шүүлтүүр хийх (Lee, Local sigma аргаар), индекс тус бүрээр болон нэгтгэн сургалтгүй ангилал хийх (K-mean аргаар), ангилалын үр дүн, анги тус бүрийн утгуудын тархалт, давтамжийн зураг, график гаргах, ялгаатай, төстэй байдал болон хамаарлыг харьцуулан шинжих зэрэг боловсруулалт хийсэн.

Сентинел-1 дагуулын SAR хэмжилтийн өндрийн тоон мэдээгээр уурхайн ухалт, овоолго хийсэн газрыг тодорхойлох боловсруулалт хийсэн. Үүнд хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудын хэсэгт өнгийн ялгарлыг сайжруулах, өндрийн тоон утгын хаялбарыг зурах, уурхайн ухашийн эзлэхүүнийг тооцоолох зэрэг боловсруулалтыг ENVI, ArcGIS программ ашиглан хийсэн.

Хүснэгт 2. Сентинел-2 дагуулын мэдээгээр хөрс, ургамалжилт, усны индекс тооцоолсон томъёо

Ургамалжилтын индекс		Усны индекс	
$NDVI = \frac{b8 - b4}{b8 + b4}$		$NDWI = \frac{b3 - b8}{b3 + b8}$	
Хөрсний цайврын индекс	Хөрсний өнгөний индекс	Хөрсний улааны индекс	
$BI = \sqrt{\frac{b4^2 + b3^2}{2}}$	$CI = \frac{b4 - b3}{b4 + b3}$	$RI = \frac{b4^2}{b3^2}$	

Ер нь хиймэл дагуулын мэдээг татаж авах, боловсруулах, шинжих, шийдвэр гаргахад тус болох мэдээлэл бэлтгэхэд чиглэсэн үндсэн 5 үе шатны үйл ажиллагаа хийгддэг бөгөөд эдгээрийн товч агуулгыг Хүснэгт 3-т үзүүлэв. Дорноговийн эвдэрсэн газрын тооллогын энэ удаагийн ажилд эхний 3 үе шатны боловсруулалт хийгдсэн гэж үзэж болно. Хиймэл дагуулын мэдээлэл боловсруулж гаргасан үр дүнг газрын мэдээгээр нягтлан шалгах хэрэгтэй. 13 сумын ургамалжилтийн индекс тооцсон үр дүнг хавсралт 6.2-с үзнэ үү.

Хүснэгт 3. Хиймэл дагуулын мэдээ татаж авах, боловсруулах, үр дүн гаргах үе шат, товч агуулга

Мэдээлэл татаж авах	Анхдагч боловсруулалт	Сэдэвчилсэн боловсруулалт	Нэгтгэсэн боловсруулалт, үнэлгээ, шинжлэл	Шийдэл, шийдвэр
<ul style="list-style-type: none"> <li>Хэрэгцээт байдлын судалгаа, үнэлгээ</li> <li>Судалгааны талбар</li> <li>Цаг хугацаа</li> <li>Мэдээний хайлт, сонголт</li> <li>Татан авалт</li> <li>Холбогдох мэдээллийн бүрдүүлэлт (надастр, хөрс, ургамал, топо мэдээ, зургүүд)</li> <li>Мэдээний бүрдэлт, чанарын хяналт</li> <li>...</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Формат хөрвүүлэлт</li> <li>Радиометрийн хувиргалт, заслага</li> <li>Газарзүйн холболт, проекц хөрвүүлэлт</li> <li>Агаар мандлын заслага</li> <li>Суурь зураг бэлтгэх</li> <li>Хээрийн судалгааны удирдамж, төлөвлөгөө гаргах</li> <li>...</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Индекс тооцоолол</li> <li>Газар дээр хийх ажиглалт, хэмжилт, зураглал</li> <li>Газрын ба дагуулын мэдээллийн үлдээ, хамаарлын шинжлэл</li> <li>Статистик тооцоолол, анализ</li> <li>Тархалт, ялгаралын шинжлэл</li> <li>Хувиргалт, шинжлэл</li> <li>Ангилал, статистик тооцоолол, анализ</li> <li>Зураглал, тайлал, тайлан</li> <li>...</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хамаарал, үлдээ холбоо, хэрэгцээ, нийцтэй байдлын шинжлэл</li> <li>Нэгдсэн үзүүлэлтийн тооцоолол, шинжлэл</li> <li>Нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ, шинжлэл</li> <li>Асуудал, шалтгаан, үр дагаварын шинжлэл</li> <li>Хүний үйл ажиллагаа, байгууллага, удирдлага, засаглалын шинжлэл</li> <li>Засал, шийдлийн хувилбарууд</li> <li>Хувилбарын шинжлэл, хэлэлцүүлэг, оновчлох тооцоолол, шинжлэл</li> <li>Тайлан, санал, зөвлөмж</li> <li>...</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нийгэм-эдийн засаг, тогтвортой хөгжлийн үр ашиг, ач холбогдлын тооцоолол, шинжлэл</li> <li>Удирдлага, засаглалын шинжлэл, оновчлох санал зөвлөмж</li> <li>Хэлэлцүүлэг</li> <li>Шийдвэрийн санал, зөвлөмж</li> <li>Хүлээлгэн өгөх, баталгаажуулах</li> <li>...</li> </ul>

### Дроны зургийн боловсруулалт

Mavic 2 pro нисгэгчгүй төхөөрөмж ашиглан төлөвлөгөөт нислэг хийлгэж нягтаршил өндөртэй агаарын зураг авч AgiSoft програм хангамж ашиглан боловсруулалтыг хийж ArcGIS программ дээр эвдэрсэн газрын талбайн хэмжээг зураглан ArcScene программ дээр зураглалыг гаргасан. Дроны зургийн боловсруулалтын үр дүнгийн талаар Алтанширээ сумын 4-р багийн нутаг дах Жоншт толгой гэх эвдэрсэн газар дээр жишээ болгон үзүүлэв.

Зураг 2. Дроны зураг ашиглан эвдрэлд орсон газрын талбайн хэмжээг тооцсон жишээ (Алтанширээ сум, Жоншт толгой)




Хээрийн хэмжилтийн үеийн фото зураг



Дроноор авсан зураг



Дроны зургийн боловсруулалт хийж эвдэрсэн газрын талбайн хэмжээг тооцоолж буй байдал



Тооцоолол хийгдсэн байдал

#### 1.3.4. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ, зардлын тооцоо

Эвдэрсэн газрыг бэлчээрийн зориулалтаар ашиглах хэмжээнд хүргэн нөхөн сэргээх ажлын зардлыг БОАЖЯ-ны Сайд, ЭБЭХ-ний Сайдын хамтарсан 2010.05.10 өдрийн 132/112 тоот тушаалаар баталсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал” болон бусад нөхөн сэргээлтийн холбогдох стандарт, аргачлал, заавар, журмын дагуу тооцсон. Нөхөн сэргээлтэнд хэрэглэх техник хэрэгслийн талаарх мэдээлэл тодорхой биш учир зардлынтгооцоонд дундаж үнэлгээг баримтласан.

#### 1.3.5. Тооллого, үнэлгээ, тооцооны үр дүн

Тооллогод нийт 148 газарт байрлах нийт 3545 га талбайг бүртгэсэн. (Хавсралт 6.2). Эвдрэлийг төрлөөр нь ангилж үзвэл:

- Ашиглалт, хайгуулын улмаас эвдрэлд орсон - 31 газрын 241 га талбай
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос эвдэрсэн - 16 газрын 176 га талбай
- Хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн талбайгаас эвдэрсэн - 58 газрын 2,777 га талбай
- Тусгай зөвшөөрөлтэй ААН ашиглаж байгаад хаяад явсан эвдэрсэн - 16 газрын 311 га талбай
- Бичил уурхайгаар эвдэрсэн - 1 газрын 2 га талбай
- Гар аргаар ашигт малтмал олборлогчдын эвдэрсэн - 22 газрын 35 га талбай.
- Нөхөн сэргээгдсэн болон нөхөн сэргээлт хийгдэж байгаа - 4 газрын 3 га талбай
  - Нөхөн сэргээлт хийсэн (ургамалжуулаагүй) - 3
  - Нөхөн сэргээлт хийгдэж байгаа - 1

Сум тус бүрээр дээрх ангиллын дагуу хүснэгтэн мэдээллийг үүсгэсэн ба тайлангийн Бүлэг 2-т хэмжилт хийхэд оролцсон албан хаагчдын мэдээлэл, эвдэрсэн газрын тоо, талбайн хэмжээ болон нөхөн сэргээлт хийгдсэн, хийгдээгүй байгаа талбайн мэдээллийг тодорхой тусгав.

### 1.3.6. ЭВДЭРСЭН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН САН

Судалгаанд хамрагдсан сум болгоноор, хэмжилт судалгааны суурь, сэдэвчилсэн зураглал болон хиймэл дагуулын мэдээлэл боловсруулалтын үр дүнд үүссэн вектор, растер мэдээллийг холбогдох атрибут мэдээллийн хамт нэгтгэн мэдээллийн санд оруулахад бэлэн болгож Захиалагчид хүлээлгэн өгсөн. Эдгээр мэдээллийг UTM 49N, WGS 84 проекцэнд, shp, img, geotiff, xls, pdf файл хэлбэрээр бэлтгэж өгсөн.

### 1.3.7. ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН, БАТАЛГААЖУУЛАЛТ

ЖЭМР ХХК энэ ажлын хүрээнд хийсэн судалгаа, зураглал, тооцооны үр дүнг 13 сумаар нэгтгэн нэгдсэн тайлан боловсруулж ажлын үр дүнг Дорноговь аймгийн БОАЖГ-т хүлээлгэн өгөв.

### 1.4. АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ХУГАЦАА

2021 оны 11-р сарын 2-оос 11-р сарын 19-ний хооронд нийт 18 хоногийн хугацаанд 13 суманд 148 эвдэрсэн газрыг бүртгэж, хэмжилт хийж зургаар баталгаажуулсан. Гэрээ байгуудагдсаны дараа хээрийн хэмжилт судалгаандаа гарсан боловч төлөвлөснөөс илүү хугацаа зарцуулсан ба судалгаанаас ирсэн даруйдаа боловсруулалтын ажилдаа орсон. Дроны зургийн боловсруулалт болон хиймэл дагуулын мэдээлэл боловсруулалтыг хийж эвдэрсэн газрын талбайн хэмжээг тооцоолон, нөхөн сэргээлтийн тооцооллыг гэрээт ажлын хугацаанд буюу 2021 оны 11-р сарын 29-ний өдөр багтаан хийж гүйцэтгэхэд хангалтгүй байсан тул хугацааг 2021 оны 12-р сарын 13-ны өдөр хүртэл сунган ажилласан.

### 1.5. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАГ

Судалгаа, үнэлгээг 7 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн баг ЖЭМР ХХК-ний Ерөнхий захирал, доктор Р.Оюуны удирдлагын дор хийж гүйцэтгэсэн. Багийн бүрэлдэхүүнд газар зохион байгуулагч, байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн, зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн орсон. Багийн гишүүдийн гүйцэтгэсэн үүрэг, хийсэн ажлыг Хүснэгт 2-т үзүүлэв.

Эвдэрсэн газрын тооллого хийх ажилд оролцсон Дорноговь аймаг болон судалгаанд хамрагдсан 13 сумын албан хаагчдын нэрсийг Хүснэгт 3-т үзүүлэв.

### Хүснэгт 4. Судалгааны багийн гишүүдийн үүрэг

№	Нэрс	Албан тушаал	Хариуцсан ажил
1	Р.Оюун	ЖЭМР ХХК, Ерөнхий захирал	Төслийн удирдлага, судалгааны аргачлал, нэгтгэсэн тайлан, хиймэл дагуулын мэдээлэл боловсруулалт
2	Д.Булганбаяр	ЖЭМР ХХК, Гүйцэтгэх захирал, Газар зохион байгуулагч	Хээрийн судалгаа, GPS хэмжилт, зураглал, эдэлбэр газар, газрын хэвлийн судалгаа, хэмжилт, нөхөн сэргээлтийн зардлын тооцоо
3	А.Батзаяа	ЖЭМР ХХК, Менежер, Үнэлгээний мэргэжилтэн	Тайлан нэгтгэл, нөхөн сэргээлтийн зардлын тооцоо

№	Нэрс	Албан тушаал	Хариуцсан ажил
4	Г.Доржсамбуу	ЖЭМР ХХК, Байгаль орчны үнэлгээний мэргэжилтэн	Хээрийн судалгаа, GPS хэмжилт, дроны зураглал боловсруулах, мэдээллийн сан үүсгэх
5	М.Дамдинпүрэвням	ЖЭМР ХХК, Ус судлаач	Дроны зураглал боловсруулах
6	А.Тамираа	ЖЭМР ХХК, Газар зохион байгуулагч	Ландсат хиймэл дагуулын мэдээлэл боловсруулалт, дроны зураглал боловсруулах, мэдээллийн сан үүсгэх
7	Б.Баасанхүү	ЖЭМР ХХК, Газар зохион байгуулагч	Хээрийн судалгаа, GPS хэмжилт, дроны зураглал боловсруулах, мэдээллийн сан үүсгэх
8	Б.Сармандах	ЖЭМР ХХК, судлаач оюутан	Хээрийн судалгаа, GPS хэмжилт, дроны зураглал боловсруулах

#### Хүснэгт 5. Эвдэрсэн газрын тооллого хийхэд оролцсон аймаг, сумын мэргэжилтнүүд

№	Нэрс	Албан тушаал
1	Д.Сүрэн	Аймгийн БОАЖГ-ын дарга
2	Д.Болормаа	Аймгийн БОАЖГ-ын Уул уурхай, үнэлгээний мэргэжилтэн
3	Т.Ганмөнх	Сайншанд сумын БОУБ
4	Ж.Майра	Зүүнбаян тосгоны зам тээвэр, харилцаа холбоо, байгаль орчин, хот тохижилт хариуцсан мэргэжилтэн
5	М.Ганбат	Их хэт сумын БОУБ
6	Б.Сайнзаяа	Айраг сумын БОУБ
7	Т.Бямбацогт	Айраг сумын ХАА тасгийн бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
8	Э.Энхсугар	Даланжаргалан сумын БОУБ
9	Г.Банзрагч	Дэлгэрэх сумын Засаг дарга
10	М.Баттулга	Дэлгэрэх сумын БОУБ
11	Э.Ундармаа	Алтанширээ сумын БОУБ
12	Э.Гомбосүрэн	Сайхандулаан сумын БОУБ
13	М.Хишигбаяр	Улаанбадрах сумын ЗДТГ-ын дарга
14	н.Энхжаргал	Улаанбадрах сумын БОУБ
15	Г.Ганмөнх	Хатанбулаг сумын Засаг даргын орлогч
16	Э.Баттүвшин	Хатанбулаг сумын БОУБ
17	Б.Мөнхцэцэг	Хөвсгөл сумын БОУБ
18	С.Оюунбат	Хөвсгөл сумын Элст багийн дарга
19	Ж.Энхцэцэг	Эрдэнэ сумын БОУБ
20	Ц.Мөнхдаваа	Өргөн сумын Засаг дарга
21	М.Түмэнбаяр	Өргөн сумын Засаг даргын орлогч
22	Г.Нямцэцэг	Өргөн сумын БОУБ
23	Б.Дүүриймаа	Мандах сумын БОУБ



## 2. ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТООЛЛОГЫН ДҮН

### 2.1. Нэгтгэсэн үрдүн


Дорноговь аймгийн 13-н сумын хэмжээнд нийт 3545 га талбай эвдэрсэн байна. Эвдэрсэн газар Даланжаргалан суманд хамгийн олон, харин Хөвсгөл суманд цөөн эвдэрсэн газартай хэрнээ газрын талбайн хэмжээгээр хамгийн их буюу нийт 13-н сумын хэмжээнд нийт эвдрэлд орсон газрын 41%-ийг эзэлж байна (Зураг 3).

Эвдэрсэн газрын талбайг сумын нутаг дэвсгэрт харьцуулж үзэхэд (Зураг 4) Даланжаргалан сум нутгийнхаа 0.24%-ийг эвдсэн байгаа нь хамгийн их, үүний дараа Хөвсгөл сум 0.17%-иар орж, Хатанбулаг сум хамгийн бага хувьтай байна.


Уурхайлалтанд өртсөн газар сумын нутагтай харьцуулахад бага байгаа хэдий ч эвдэрсэн газар нь гол усны эрэг сав, чийг хуримтлалын гуу жалга, уулын хөндийн үржил шимт бэлчээр нутагт байгаа учраас экосистемд учирч байгаа нөлөө, үр дагавар их юм. Энэ удаагийн судалгаагаар эвдэрсэн газрын бүртгэл, судалгааг хийж нөхөн сэргээлтийн урьдчилсан тооцоог гаргасан. Цаашид ус, хөрс, ургамлын судалгааг нарийвчлан хийж байгальд орчинд учруулсан хохирлын үнэлгээг тогтоох шаардлагатай.

Уурхай ба гар аргаар олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын талбайг харьцуулж үзэхэд Даланжаргалан, Айраг, Иххэт сумдад уурхайн газар, Сайхандулаан, Мандах сумдад нинжа нарын сүйтгэсэн газар давамгайлж байна (Зураг 5). Эвдэрсэн газрыг төрлөөр нь авч үзвэл Хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас эвдэрсэн газар хамгийн их буюу 78%-ийг, бичил уурхайгаас эвдэрсэн хамгийн бага буюу 0.1%-ийг эзэлж байна (Зураг 6).

Зураг 3. Эвдэрсэн газрын талбайд сум бүрийн эзлэх хувь



Зураг 4. Эвдэрсэн газрын сумын нутагт эзлэх хувь



Зураг 5. Эвдэрсэн талбайн хэмжээ, га





График дээрх тоо эвдэрсэн газрын талбайн хэмжээ (га)-г заана.

Зураг 6. Эвдэрсэн газрын төрөл, талбайн хэмжээ га



**2.1.1. ЭВДЭРСЭН ГАЗРЫН ТАЛБАЙ, ОВООЛГО, УХШИЙН ЭЗЛЭХҮҮН**

Эзэнгүй, орхигдсон болон зөвшөөрөлгүй олборлолт явуулсан 63 газрын талбайн хэмжээ, овоолго, ухшийн эзлэхүүнийг агаарын зураглалын боловсруулалтын үр дүнгээр тооцолсон бол үлдсэн 85 газар буюу одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа, олборлолтын улмаас эвдрэлд орсон талбайн хэмжээг хиймэл дагуулын мэдээл ашиглан тооцоолсон.

Нийт 3544.8 га талбайн 31% буюу 1105.0 га талбайд 15,488.2 мян.м<sup>3</sup> овоолго, 15% буюу 542.6 га талбайд 15546.1 мян.м<sup>3</sup> ухаш үүссэн бол 54% буюу 1897.2 га<sup>1</sup> талбайн газрын гадаргын төрх байдал өөрчлөгдөж эвдрэл үүссэн байна. Сум тус бүрийн овоолго, ухшийн хэмжээг доорх хүснэгтээс үзнэ үү.

**Хүснэгт 6. Эвдэрсэн газрын талбай, овоолго, ухшийн эзлэхүүн**

Сумын нэр	Овоолго		Ухаш		Бусад эвдэрсэн газар, га	Нийт эвдэрсэн талбай, га	Нийт эзлэхүүн, мян.м <sup>3</sup>
	талбай га	эзлэхүүн, мян.м <sup>3</sup>	талбай га	эзлэхүүн, мян.м <sup>3</sup>			
Айраг	318.8	4,226.8	139.6	1,479.1	34.6	493.0	5666.6
Алтанширээ	8.5	187.3	2.5	60.3	2.5	13.5	247.6
Даланжаргалан	475.3	1,699.8	300.6	944.6	253.6	1029.5	2644.3
Дэлгэрэх	6.1	103.6	0.8	23.8	1.0	7.9	127.4
Иххэт	268.5	8,611.5	69.4	11,949.5	21.4	359.4	20572.0
Мандах	0.0	-	1.7	12.9	10.6	12.3	12.9
Өргөн	8.5	318.3	7.8	506.0	96.4	112.7	824.3
Сайншанд	3.0	80.0	8.7	329.1	0.0	11.7	409.1
Сайхандулаан	2.9	47.4	4.2	86.3	15.9	23.1	79.1
Улаанбадрах	0.0	-	0.0	-	11.7	11.7	0.0
Хатанбулаг	2.5	105.8	0.3	5.3	0.0	2.9	111.2
Хөвсгөл	0.1	1.2	0.1	1.1	1447.4	1447.6	2.3
Эрдэнэ	10.7	106.5	6.8	148.0	2.1	19.6	254.5
<b>Нийт</b>	<b>1105.0</b>	<b>15488.2</b>	<b>542.6</b>	<b>15546.1</b>	<b>1897.2</b>	<b>3,544.80</b>	<b>30,951.31</b>

**2.1.2. Нөхөн сэргээлтийн тооцоо**

Дорноговь аймгийн хэмжээнд эвдрэлд орсон 3,545 га талбайгаас нөхөн сэргээлтийг 82 газарт буюу 673 га талбайд тооцход 6.9 тэрбум төг зарцуулахаар урьдчилсан тооцоо гарсан. Үүнийг сумаар харьцуулвал дараах байдлаар гарч байна.

**Хүснэгт 7. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн зардлын дүн (сумаар)**

№	Сумын нэр	Нөхөн сэргээлтийн зардлын дүн (төг)
1	Айраг	1,886,094,688.46
2	Алтанширээ	67,107,330.84
3	Даланжаргалан	387,212,256.60
4	Дэлгэрэх	30,834,872.90
5	Их хэт	3,805,366,311.46
6	Мандах	46,273,538.12
7	Өргөн	446,546,096.58
8	Сайншанд	48,932,381.72
9	Сайхандулаан	113,609,833.19
10	Улаанбадрах	-
11	Хатанбулаг	44,240,614.58

<sup>1</sup> Үйл ажиллагаа явуулж байгаа болон түр хугацаанд ажиллахгүй байгаа уурхайн ухаш, овоолгын хэмжээг тус талбайд оруулж тооцсон болно.

№	Сумын нэр	Нөхөн сэргээлтийн зардлын дүн (төг)
12	Хөвсгөл	1,338,972.98
13	Эрдэнэ	117,821,184.40
	<b>Нийт</b>	<b>6,995,378,082.83</b>


## 2.2. 13 СУМЫН ЭВДЭРСЭН ГАЗАР

### 2.2.1. АЙРАГ


Айраг суманд эвдэрсэн нийт 37 газар бүртгэгдсэн ба 1, 2, 3-р багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 493 га, овоолгын эзлэхүүн 4,226.8 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 1,479.1 мян.м<sup>3</sup> байна.

Нийт эвдрэлд орсон талбайн 243.1 га буюу 49.3% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас, 141.2 га буюу 28.6% нь ашиглалт, хайгуулын улмаас, 100.1 га буюу 20.3% нь түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогчдын үйл ажиллагаанаас, 5.3 га буюу 1.1% нь гар аргаар ашигт малтмал олборлогчдын нөлөөгөөр, 2.3 га буюу 0.5% нь бичил уурхайгаас, 0.98 га буюу 0.2% нь тусгай зөвшөөрөлтэй ААН ашиглаж байгаад хаяад явснаас болж тус тус эвдрэлд орсон байна.

Эдгээр нь Хайрт, Алтад, Бор толгой, 19-р илрэл, Найдвар, 47-ийн гүүр, Хөх дэл, Хүрэн, Бужгар, Нэргүй толгой, Алаг өндөр, Хормойн бууц, Баруун цагаан дэл, Цагаан дэлийн агуй, Жоншт толгой, Модот, Цагаан-Овоо, Элэгний хүрэн өндөр, Сөрт, Яшил, ХонгорынОвоо гэх газруудад байрлана.



Зураг 7. Айраг сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ






### 2.2.2. АЛТАНШИРЭЭ

Алтанширээ суманд эвдэрсэн 3 газар бүртгэгдсэн ба 1, 4-р багийн нутагт Жоншт толгой, Өмнө бага чулуу, Цагаан дэл гэх газруудад байрлана. Эвдэрсэн газрын талбай 13.5 га, овоолгын эзлэхүүн 187.3 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 60.3 мян.м<sup>3</sup> байна.

Нийт эвдрэлд орсон талбайн 11.1 га буюу 82% ашиглалт, хайгуулын улмаас, 2.4 га буюу 18% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас эвдэрсэн байна.



## Зураг 8. Алтанширээ сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ




## 2.2.3. ДАЛАНЖАРГАЛАН


Даланжаргалан суманд эвдэрсэн 37 газар бүртгэгдсэн ба 1, 2, 3, 4-р багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 1,029.5 га, овоолгын эзлэхүүн 1,699.8 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 944.6 мян.м<sup>3</sup> байна.

Нийт эвдрэлд орсон талбайн 900.6 га буюу 87.5% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас эвдэрсэн бол 83.1 га буюу 8.1% нь ашиглалт, хайгуулын улмаас, 28.8 га буюу 2.8% нь тусгай зөвшөөрөлтэй ААН ашиглаж байгаад хаяад явсан, 14.9 га буюу 1.5% нь гар аргаар ашигт малтмал олборлогчдын нөлөөгөөр эвдэрсэн байна.


Харин 1.9 га-д нөхөн сэргээлт хийж, 0.2 га-г нөхөн сэргээж байна. Эдгээр нь Хонгор-3, Сэрүүн цагаан, Майхан дэл, Холбоо цагаан, Адаг ханан, Дунд ханан, Антены ард, Бурхант гэх газруудад байрлана.



Зураг 9. Даланжаргалан сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ








### 2.2.4. Дэлгэрэх

Дэлгэрэх сумын Аман шанд багийн Гитийн шанд гэх газарт 7.94 га бүхий 1 түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газар бүртгэгдсэн. Тус эвдэрсэн газарт 103.6 мян.м<sup>3</sup> овоолго, 23.8 мян.м<sup>3</sup> ухаш байна.

Зураг 10. Дэлгэрэх сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ




### 2.2.5. Иххэт


Иххэт суманд эвдэрсэн 17 газар бүртгэгдсэн ба 1, 2-р багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 359.4 га, овоолгын эзлэхүүн 8,611.5 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 11,949.5 мян.м<sup>3</sup> байна. Нийт эвдрэлд орсон талбайн 111.8 га буюу 31.1% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас эвдэрсэн бол 245.4 га буюу 68.3% нь тусгай зөвшөөрөлтэй ААН ашиглаж байгаад хаяад явсан, үлдсэн 2.2 га буюу 0.6% нь ашиглалт, хайгуулын улмаас эвдрэлд орсон байна.



Зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй талбай нь 2-р багийн нутаг дах Цагаан элгэн гэх газар бөгөөд энд "Болор Оюун жонш" ХХК, "Жимэнг" ХХК, "Хүрэн бэлчир" ХХК, "Өнөр Жонш" ХХК, "Болор Гол" ХХК, "Цагаан Элгэн" ХХК, Төвшин" ХХК, "Борж Овоот" ХХК, "Болдлан" ХХК-иуд, 1-р багийн нутаг дах Зүүн цагаан дэл гэх газарт уурхайн үйл ажиллагаа тус тус явуулж байна.

Зураг 11. Иххэт сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ





**2.2.6. МАНДАХ**

Мандах суманд эвдэрсэн 11 газар бүртгэгдсэн ба Өехий, Баянхошуу, Алхантаэй багийн нутагт байрлана.

Эвдэрсэн газрын талбай 12.3 га, ухшийн эзлэхүүн 12.9 мян.м<sup>3</sup> байна. Нийт эвдрэлд орсон талбайн 1.9 га буюу 15.4% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн талбайгаас эвдэрсэн бол 5.8 га буюу 46.8% нь түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогчдын үйл ажиллагаанаас эвдэрсэн, 0.15 га буюу 1.2% нь ашиглалт, хайгуулын улмаас эвдрэлд орсон, 0.96 га буюу 7.8% нь нөхөн сэргээлт хийгдсэн, 3.5 га буюу 28.8% нь гар аргаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанаас эвдэрсэн байна.

Эдгээр нь Үхэр чулуут, Элстэй, Ногоон чулуут, Хар майхан, Нарийн худаг, Үнэгэд, Хошуу хонд, Хэмхдэг гэх газарт байрлах ба "Их говь энерги" ХХК, "Эрдэнэс цагаан суварга" ХХК, "Монголын төмөр зам" ХХК-иуд үйл ажиллагаа явуулсан байна.




Зураг 12. Мандах сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ



### 2.2.7. ӨРГӨН

Өргөн суманд эвдэрсэн 8 газар бүртгэгдсэн ба Сүмбэр, Сүмийн булаг багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 112.7 га, овоолгын эзлэхүүн 318.3 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 506.0 мян.м<sup>3</sup> байна. Нийт эвдрэлд орсон талбайн 57.6 га буюу 51% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас, 55.1 га буюу 49% нь түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогчдын үйл ажиллагаанаас тус тус эвдэрсэн байна. Эдгээр газрууд нь Хонгор толгой, Хавцгай, Адуун чулуу, Түшлэг, Шавгийн хошуу (Сэнс) гэх газарт байрлах ба “Монцемент буйлдинг материал” ХХК, “Ялгуун интерншнл” ХХК-иуд үйл ажиллагаа явуулсан байна.




Зураг 13. Өргөн сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ




### 2.2.8. САЙНШАНД

Сайншанд суманд эвдэрсэн 6 газар бүртгэгдсэн, эдгээр нь 5-8-р багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 11.7 га, овоолгын эзлэхүүн 80.0 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 329.1 м<sup>3</sup> байна. Нийт эвдрэлд орсон талбайн 4.4 га буюу 38% нь тусгай зөвшөөрөлтэй ААН ашиглаж байгаад хаяад явсан, үлдсэн 7.3 га буюу 62% нь түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлогчдын үйл ажиллагаанаас эвдрэлд орсон байна.



Зураг 14. Сайншанд сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ



### 2.2.9. САЙХАНДУЛААН


Сайхандулаан суманд эвдэрсэн 14 газар бүртгэгдсэн ба Жаргалант, Өлзийт, Улаан шороот багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 23.1 га, овоолгын эзлэхүүн 47.4 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 86.3 мян.м<sup>3</sup> байна.

Нийт эвдрэлд орсон талбайн 11.2 га буюу 48.4% нь гар аргаар ашигт малтмал олборлогчдын нөлөөгөөр, 11.6 га буюу 50.3% нь тусгай зөвшөөрөлтэй ААН ашиглаж байгаад хаяад явснаас, 0.3 га буюу 1.4% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон байна.

Эдгээр нь Хар овоо, Жаргалант судаг, Улаан тойром шанаа, Баянхошууны сайр Холахонд, Тольт, Бичигтийн хадны баруун зүүн урд, Бичигт зүүн 2, Гэр хад, Цац, Модны бууц гэх газруудад байрлана.



Зураг 15. Сайхандулаан сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ






### 2.2.10. ХАТАНБУЛАГ

Хатанбулаг сумын Агаруут багийн Цагаан хад гэх газарт 2.9 га бүхий 1 ашиглалт, хайгуулын улмаас эвдрэлд орсон газар тоологдсон ба овоолгын эзлэхүүн 105.8 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 5.3 мян.м<sup>3</sup> байна.

Зураг 16. Хатанбулаг сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ



### 2.2.11. Хөвсгөл

Хөвсгөл суманд эвдэрсэн 8 газар бүртгэгдсэн ба Эмт багийн нутагт байрлана. Эвдэрсэн газрын талбай 1,447.6 га, овоолгын эзлэхүүн 1.2 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 1.1 мян.м<sup>3</sup> байна. Нийт эвдрэлд орсон талбайн 1,447.4 га буюу 99.98% нь хариуцах эзэнтэй буюу тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн үйл ажиллагаанаас, 0.2 га буюу 0.02% нь ашиглалт, хайгуулын улмаас эвдрэлд орсон байна. Тус эвдэрсэн газруудад "Саруулсайн" ХХК, "Си Өү Эй Эл" ХХК, "Сора интернэшнл" ХХК-иуд үйл ажиллагаа



явуулсан байна.

## Зураг 17. Хөвсгөл сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ




## 2.2.12. Улаанбадрах

Улаанбадрах сумын Аргалант багийн Баян монгол толгойн зүүн талд 11.7 га бүхий 1 газрыг бүртгэлд хамруулсан. Уг газар нь “Бадрах Энержи” ХХК-ний үйл ажиллагаанаас эвдрэлд орсон байна. Хээрийн судалгааны үед тус газар дээр очоогүй тул фото зургаар баримтжуулаагүй ба хиймэл дагуулын мэдээллээс талбайн хэмжээг зурагласан (Зураг 18).


## 2.2.13. Эрдэнэ

Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн Хунхат гэх газарт 19.6 га бүхий 1 эвдэрсэн газар тоологдсон ба овоолгын эзлэхүүн 106.5 мян.м<sup>3</sup>, ухшийн эзлэхүүн 148.0 мян.м<sup>3</sup> байна. Тус газарт 10 нөхөрлөл 50 га талбайд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан ба эдгээр нөхөрлөлүүдийн үйл ажиллагаагаар эвдэрч үлдсэн байна (Зураг 19).

Зураг 18. Улаанбадрах сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ



Зураг 19. Эрдэнэ сумын эвдэрсэн газрын байршил, талбайн хэмжээ



---

### 2.3. ЭВДЭРСЭН ГАЗРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ

---

13 сумын эвдэрсэн газрын талбай тус бүрийн тодорхойлолтыг (Хүснэгт 8)-д үзүүлэв. Эвдэрсэн газрын тодорхойлолтонд тухайн газрын сум, багийн нэр, газрын нэр, хариуцагч, эвдрэлийн байдал, эвдэрсэн болон нөхөн сэргээсэн талбай байдал зэрэг мэдээллийг оруулсан.

## Хүснэгт 8. Эвдэрсэн газрын тодорхойлолт (талбай тус бүрээр)

Хэмжилт, судалгааны цэгийн дугаар	1	2	3	4
Он сар өдөр	2021.11.16	2021.11.16	2021.11.16	2021.11.16
Засаг захиргааны харъяалал газрын нэр	Дорноговь аймаг, Айраг сум, Нүдэн 3-р баг Хайрт	Дорноговь аймаг, Айраг сум, Нүдэн 3-р баг Хайрт	Дорноговь аймаг, Айраг сум, Нүдэн 3-р баг Өмнөд алтад	Дорноговь аймаг, Айраг сум, 2-р баг Алтад
Хариуцагч	Эзэн хариуцагчгүй	"Алтраг Ахас" ХХК	"Хэрлэн импекс" ХХК	"Би Ти Девелопмент" ХХК
Байршил (WGS84 GEO)	Уртраг-109.37173	Уртраг-109.36066	Уртраг-109.38363	Уртраг-109.38169
	Өргөрөг-45.74870	Өргөрөг-45.75368	Өргөрөг-45.75788	Өргөрөг-45.76408
Өндөршил, м	1030	1054	1042	1034
Талбайн хэмжээ	Талбай-43.9 га	Талбай-32.8 га	Талбай-12.6 га	Талбай-16.3 га
Эвдрэлийн төрх, хэлбэр, тэмдэглэгээ	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.
Юунаас болж эвдрэл үүссэн	Хайрга дайрга олборлолтоос эвдэрсэн.	Хайрга дайрга олборлолтоос эвдэрсэн.	Жонш олборлолтоос эвдэрсэн.	Жонш олборлолтоос эвдэрсэн.
Ургамлан нөмрөгийн нөмрөгийн өнөөгийн төлөв байдал	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан
Нөхөн сэргээлт хийсэн эсэх	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Үйл ажиллагаа явуулж байгаа.	Үйл ажиллагаа явуулж байгаа.

Хэмжилт, судалгааны цэгийн дугаар	5	6	7	8
Он сар өдөр	2021.11.16	2021.11.16	2021.11.16	2021.11.16
Засаг захиргааны харьяалал газрын нэр	Дорноговь аймаг, Айраг сум, 2-р баг 19-р илрэл	Дорноговь аймаг, Айраг сум, 4-р баг Бор толгой	Дорноговь аймаг, Айраг сум, 2-р баг Бор толгой	Дорноговь аймаг, Айраг сум, 2-р баг Найдвар
Хариуцагч	“Монголросцветмет” ТӨҮГ	“Монголросцветмет” ТӨҮГ	“Талст бурхант” ХХК	“Өргөн мандалговь майнинг” ХХК
Байршил (WGS84 GEO)	Уртраг-109.34618	Уртраг-109.32496	Уртраг-109.32918	Уртраг-109.27774
	Өргөрөг-45.82060	Өргөрөг-45.81574	Өргөрөг-45.83643	Өргөрөг-45.83289
Өндөршил, м	1052	1065	1037	1033
Талбайн хэмжээ	Талбай-1.4 га	Талбай-23.6 га	Талбай-0.7 га	Талбай-4.2 га
Эвдрэлийн төрх, хэлбэр, тэмдэглэгээ	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан	Тэгш талбайг техникээр ухсан	Тэгш талбайг техникээр ухсан
Юунаас болж эвдрэл үүссэн	Жонш олборлолтоос эвдэрсэн.	Жонш олборлолтоос эвдэрсэн.	Хайгуулын талбай	Ашиглалтын лиценз
Ургамлан нөмрөгийн нөмрөгийн өнөөгийн төлөв байдал	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан
Нөхөн сэргээлт хийсэн эсэх	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон

Хэмжилт, судалгааны цэгийн дугаар	9	10	11	12
Он сар өдөр	2021.11.16	2021.11.16	2021.11.16	2021.11.16
Засаг захиргааны харьяалал газрын нэр	Дорноговь аймаг, Айраг сум, 2-р баг 47-гийн гүүр	Дорноговь аймаг, Айраг сум, 1-р баг Хөх дэл	Дорноговь аймаг, Айраг сум, 1-р баг Хүрэн	Дорноговь аймаг, Айраг сум, 1-р баг Бужгар
Хариуцагч	Эзэн хариуцагчгүй	“Хөх төр” ХХК	“Айвору” ХХК	“Дорноговийн үйлс” ХХК
Байршил (WGS84 GEO)	Уртраг-109.27351	Уртраг-109.18565	Уртраг-109.16087	Уртраг-109.17165
	Өргөрөг-45.82947	Өргөрөг-45.79104	Өргөрөг-47.63633	Өргөрөг-45.79929
Өндөршил, м	1042	1101	1109	1095
Талбайн хэмжээ	Талбай-4.3 га	Талбай-8.3 га	Талбай-16.2 га	Талбай-18.8 га
Эвдрэлийн төрх, хэлбэр, тэмдэглэгээ	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.
Юунаас болж эвдрэл үүссэн	Төмөр замын шороо авсан	Ашиглалтын лиценз	Ашиглалтын лиценз	Ашиглалтын лиценз
Ургамлан нөмрөгийн нөмрөгийн өнөөгийн төлөв байдал	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан
Нөхөн сэргээлт хийсэн эсэх	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон

Хэмжилт, судалгааны цэгийн дугаар	13	14	15	16
Он сар өдөр	2021.11.16	2021.11.16	2021.11.16	2021.11.16
Засаг захиргааны харьяалал газрын нэр	Дорноговь аймаг, Айраг сум, 1-р баг Бужгар	Дорноговь аймаг, Айраг сум, 1-р баг Нэргүй толгой	Дорноговь аймаг, Айраг сум, 3-р баг Алаг өндөр	Дорноговь аймаг, Айраг сум, 3-р баг Хормойн бууц
Хариуцагч	“Монголросцветмет” ТӨҮГ	Бужгар орд ХХК	Эзэн хариуцагчгүй	Эзэн хариуцагчгүй
Байршил (WGS84 GEO)	Уртраг-109.18041	Уртраг-109.28315	Уртраг-109.25548	Уртраг-109.20898
	Өргөрөг-45.80443	Өргөрөг-45.80337	Өргөрөг-45.68168	Өргөрөг-45.66562
Өндөршил, м	1083	1064	1086	1088
Талбайн хэмжээ	Талбай-65.4 га	Талбай-9.7 га	Талбай-0.9 га	Талбай-0.3 га
Эвдрэлийн төрх, хэлбэр, тэмдэглэгээ	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.	Тэгш талбайг техникээр ухсан.
Юунаас болж эвдрэл үүссэн	Ашиглалтын лиценз	Ашиглалтын лиценз	Жонш олборлосон.	Жонш олборлосон.
Ургамлан нөмрөгийн нөмрөгийн өнөөгийн төлөв байдал	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан	Ургамлан нөмрөг устсан
Нөхөн сэргээлт хийсэн эсэх	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Үйл ажиллагаа явуулж байгаа	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон	Нөхөн сэргээлт хийлгүй орхисон



Хэмжилт, судалгааны цэгийн дугаар	17	18	19	20
Он сар өдөр	2021.11.16	2021.11.16	2021.11.17	2021.11.17
